



**2024 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН**


ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА 2024 ОНЫ III УЛИРАЛД

1. Үнэт цаасны арилжаа

2024 оны гуравдугаар улиралд нийт 187 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 141 ХК-ийн 242.50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 895.38 сая ширхэг хувьцааг, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 110.38 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.22 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 4.40 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 7.49 сая ширхэг нэгж эрхийг, өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 615.60 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 6.17 сая ширхэг өрийн хэрэгслийг тус тус арилжиж, нийт 972.90 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 910.28 сая ширхэг үнэт цаас арилжигдсан.

Нийт арилжааны үнийн дүнгийн 24.93 хувь буюу 242.50 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 11.35 хувь буюу 110.38 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжаа, 0.45 хувь буюу 4.40 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 63.28 хувь буюу 615.60 тэрбум төгрөгийг өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 5.20 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 4.86 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.58 дахин өссөн байна.


НИЙТ АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

ҮНЭТ ЦААС		2023.01.02-2023.09.29		2024.01.01-2024.09.30	
		ширхэг	үнийн дүн	ширхэг	үнийн дүн
ХУВЬЦАА	Анхдагч	623,099,479	335,950,081,541.00	172,305,616.00	24,813,677,184.00
	Хоёрдогч	387,602,501	131,067,127,406.43	723,084,165.00	217,689,088,763.16
ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС	Анхдагч	290,000	29,000,000,000.00	850,000.00	85,000,000,000.00
	Хоёрдогч	164,039	15,726,905,420.00	377,258.00	25,383,570,460.00
ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	Анхдагч	755,000	75,500,000,000.00	5,300,000.00	530,000,000,000.00
	Хоёрдогч	216,138	21,624,586,943.80	878,290.00	85,607,357,440.00
ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН	Анхдагч	-	-	-	-
	Хоёрдогч	8,461,718	5,336,644,816.74	7,493,966.00	4,409,807,252.36
Нийт		1,020,588,875	614,205,346,127.97	910,289,295.00	972,903,501,099.52

1.1 Хувьцааны зах зээлийн арилжаа


Тайлант хугацаанд нийт 187 удаагийн арилжаагаар 141 ХК-ийн 242.50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 895.38 сая ширхэг хувьцаа арилжигдсанаас 9.98 хувь буюу 24.13 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 90.02 хувь буюу 217.68 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 71.68 хувь буюу 156.04 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 26.70 хувь буюу 58.13 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 1.61 хувь буюу 3.51 тэрбум төгрөгийн гүйлгээг тендер саналын арилжаа арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Анхдагч зах зээлийн арилжаа

“Ард кредит ББСБ” ХК нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 428 дугаар тогтоол болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/140 тоот тушаалын дагуу “Ард кредит ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргасан буй нэг бүр нь 106 төгрөгийн үнэтэй, нийт 8,904,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 84,000,000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар 9,105,862,160 төгрөгийн үнийн дүн бүхий 85,904,360 ширхэг хувьцааг худалдан авахаар 1,583 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон

андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 500,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 94.6 хувиар хувь тэнцүүлэн хуваарилсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2/709 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр амжилттай эхлүүлсэн.

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн IPO амжилттай болов.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 183 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/81 тоот тушаал, “Инвескор капитал ҮЦК” ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 9-ний өдрийн А-24/144 тоот албан бичгийг тус тус үндэслэн “Эм Жи Эл Акуа” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 174 төгрөгийн үнэтэй, нийт 15,234,677,184 төгрөгийн үнийн дүн бүхий 87,555,616 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 15,277,687,200 төгрөгийн үнийн дүн бүхий 87,802,800 ширхэг хувьцааг худалдан авахаар 485 хөрөнгө оруулагчдаас нийт 501 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 600 ширхэг буюу 104,400 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 98.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 1/2031 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

“Гранд системс” ХК-ийн IPO амжилттай болов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 792 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/164 тоот тушаал, “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 500-АБ-49/02/24 албан тоотыг тус тус үндэслэн “Гранд системс” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 900 төгрөгийн үнэтэй, нийт 675,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 750,000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар 683,737,200 төгрөгийн үнийн дүн бүхий 759,708 ширхэг хувьцааг худалдан авахаар 134 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг 100% биелүүлж, үлдсэн дүнг 97,5%-иар хувь тэнцүүлэн нийлүүлэхээр хуваарилсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1/2401 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 07 дугаар сарын 02-ний өдөр амжилттай эхлүүлсэн.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 217.68 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 723.08 сая ширхэг хувьцаа арилжсан байна. Нийт 141 ХК-ийн үнэт цаас

арилжигдсанаас 96 компанийн үнэт цаасны ханш өсөж, 43 компанийн үнэт цаасны ханш буурч,
2 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
GOV	ГОВЬ	280,904,063	1	GOV	ГОВЬ	71,814,834,964.25
BOGD	БОГД БАНК	83,213,745	2	KHAN	ХААН БАНК	28,975,867,846.00
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	46,768,230	3	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	13,095,781,659.00
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС ХК	42,017,937	4	INV	ИНВЕСКОР ББСБ	9,508,999,285.00
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	32,493,457	5	GLMT	ГОЛОМТ БАНК	9,209,154,472.75
KHAN	ХААН БАНК	27,225,176	6	MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	8,418,280,641.54
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	24,352,675	7	CUMN	ПРЕМИУМ НЭКСУС ХК	7,409,644,957.78
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	22,930,414	8	APU	АПУ	7,259,769,920.01
ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	18,960,124	9	BOGD	БОГД БАНК	7,023,073,284.06
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	18,352,682	10	XAC	ХАС БАНК	5,714,742,951.34
QRAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК	16,974,360	11	TTL	ТАВАН ТОЛГОЙ	5,625,195,950.00
SEND	СЭНДЛИ БСББ	16,921,731	12	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	4,842,617,532.00
AMT	ЭРДЭНЭС СОЛЮШИНС	15,680,341	13	MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	4,677,621,018.34
XAC	ХАС БАНК	8,145,489	14	TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	3,979,450,580.00
MFC	МОНОС ХҮНС	7,993,581	15	QRAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК	3,574,719,723.52
GLMT	ГОЛОМТ БАНК	7,877,116	16	SEND	СЭНДЛИ БСББ	2,983,573,487.66
APU	АПУ	7,159,271	17	GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	2,938,908,252.93
NEH	ДАРХАН НЭХИЙ	5,386,258	18	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,985,958,212.88
MGLA	ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК	5,156,563	19	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1,970,863,539.73
UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	4,845,924	20	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	1,701,218,080.81
TUM	ТҮМЭН ШУВУУТ	4,789,105	21	TUM	ТҮМЭН ШУВУУТ	1,683,979,529.89
SBM	ТӨРИЙН БАНК	3,376,345	22	SBM	ТӨРИЙН БАНК	1,669,650,056.40
BODI	БОДЬ ДААТГАЛ	2,198,783	23	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,482,098,114.09
OLL	ОЛЛОО	2,044,882	24	AIC	АРД ДААТГАЛ ХК	1,013,805,940.36
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,667,131	25	TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	971,996,075.00
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	1,560,070	26	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	965,265,037.91
MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	1,556,461	27	MGLA	ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК	924,085,915.66
AIC	АРД ДААТГАЛ ХК	1,438,167	28	BNG	БЯАНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	912,230,420.00
INV	ИНВЕСКОР ББСБ	1,360,754	29	MFC	МОНОС ХҮНС	716,439,871.39
JTB	ЖЕНКО ТУР БҮРО	1,345,272	30	CNF	КРИПТО ҮНДЭСТЭН	655,752,740.00
ДҮН		714,696,107.00				213,705,580,060.30
НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ			98.84			98.17

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.09.29	2024.09.30	/төг/	/хувь/
TVL	ТАВИЛГА	6	83,400	2,412.00	16,980.00	14,568.00	603.98
ESV	ЭРЭЭНЦАВ	7	79,720	1,983.00	12,000.00	10,017.00	505.14
KEK	МОНГОЛ КЕРАМИК	983	5,545,010	1,725.00	8,900.00	7,175.00	415.94
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	32,493,457	8,418,280,642	108.17	370.27	262.10	242.30
NKT	НАКО ТҮЛШ	24,053	973,601	24.15	77.00	52.85	218.84
BTG	БАЯНТЭЭГ	1,068	37,644,770	20,000.00	59,500.00	39,500.00	197.50
TTL	ТАВАН ТОЛГОЙ	218,671	5,625,195,950	11,000.00	32,440.00	21,440.00	194.91
SON	ЖИДАКС	34,008	20,245,834	202.00	588.00	386.00	191.09
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	24,352,675	1,970,863,540	48.00	138.00	90.00	187.50
HBZ	ХҮННУ МЕНЕЖМЕНТ	37,992	54,798,724	1,200.00	3,269.00	2,069.00	172.42
HSX	ХИШИГ УУЛ	795	2,247,409	1,602.00	4,200.00	2,598.00	162.17
UNS	УЛААНСАН	49,560	201,913,334	2,200.00	5,380.00	3,180.00	144.55
TEE	ТЭЭВЭР ДАРХАН	359	6,651,980	9,500.00	23,000.00	13,500.00	142.11
SHG	ШАРЫН ГОЛ	27,666	32,468,275	625.00	1,500.00	875.00	140.00
NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДТЭЛ	1,490	3,635,550	1,380.00	2,883.00	1,503.00	108.91
HAM	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	127	317,712	1,610.00	3,236.00	1,626.00	100.99
GTJ	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	548	588,548	675.00	1,350.00	675.00	100.00
MNS	МОННООС	727	22,903,890	15,500.00	30,620.00	15,120.00	97.55
HBO	ХАЙ БИ ОЙЛ	250,436	6,613,857	25.00	47.98	22.98	91.92
MNG	МАНДАЛ ГОВЬ ИМПЭКС	26	39,826	937.00	1,751.00	814.00	86.87
RMC	РЕМИКОН	1,025,481	51,917,674	33.01	60.00	26.99	81.76
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	1,560,070	1,701,218,081	900.00	1,628.00	728.00	80.89
HVL	ХӨВСГӨЛ	3	439	83.63	146.24	62.61	74.87
SHV	ШИВЭЭ ОВОО	5,876	11,168,997	1,325.00	2,300.00	975.00	73.58
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС ХК	42,017,937	7,409,644,958	107.50	181.02	73.52	68.39
GFG	СИЛК НЕТ	115	121,091	900.00	1,512.00	612.00	68.00
ABH	АР БАЯНХАНГАЙ	640	620,948	508.00	846.00	338.00	66.54
SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	1,094	89,019,900	60,050.00	100,000.00	39,950.00	66.53
UBH	УЛААНБААТАР ХИВС	488	20,332,380	29,100.00	47,880.00	18,780.00	64.54
HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	2,456	2,666,722	529.00	866.00	337.00	63.71

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.09.29	2024.09.30	/төг/	/хувь/
TNGR	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК	89,999	598,316,905	7,505.00	4,382.00	(3,123.00)	(41.61)
CNF	КРИПТО ҮНДЭСТЭН	13,414	655,752,740	52,000.00	33,100.00	(18,900.00)	(36.35)
JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	105,295	8,569,619	130.00	83.36	(46.64)	(35.88)
MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	1,215,214	965,265,038	800.00	589.71	(210.29)	(26.29)
ONH	ӨНДӨРХААН	84	1,245,620	15,880.00	12,000.00	(3,880.00)	(24.43)
BUK	УБ-БУК	60,126	18,972,235	396.00	303.00	(93.00)	(23.48)
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	142	586,300	5,420.00	4,300.00	(1,120.00)	(20.66)
SDT	ХОТ ДЕВЕЛОПМЕНТ	1,054	105,489	109.00	86.70	(22.30)	(20.46)
HSR	ХАСУ-МАНДАЛ	243	499,529	2,731.00	2,200.00	(531.00)	(19.44)
GHC	ГАН ХИЙЦ	176	1,063,700	6,950.00	5,700.00	(1,250.00)	(17.99)
APU	АПУ	7,159,271	7,259,769,920	1,189.00	985.84	(203.16)	(17.09)
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	41	105,750	3,050.00	2,550.00	(500.00)	(16.39)
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,667,131	4,842,617,532	3,180.00	2,683.00	(497.00)	(15.63)
TSA	ЦАГААНТОЛГОЙ	14	8,544	718.00	610.30	(107.70)	(15.00)
GOV	ГОВЬ	280,904,063	71,814,834,964	296.86	255.01	(41.85)	(14.10)
AIC	АРД ДААТГАЛ ХК	1,438,167	1,013,805,940	797.93	688.99	(108.94)	(13.65)
BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	436	219,864	575.00	500.00	(75.00)	(13.04)
BOE	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	148	530,000	4,360.00	3,800.00	(560.00)	(12.84)
JGV	ЖУУЛЧИН ГОВЬ	72	224,758	3,130.00	2,746.00	(384.00)	(12.27)
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	130,427	3,979,450,580	27,960.00	24,540.00	(3,420.00)	(12.23)
ATR	АТАР-ӨРГӨӨ	2,921	95,739,920	45,000.00	39,900.00	(5,100.00)	(11.33)
ADL	АДУУН ЧУЛУУН	18,491	9,251,845	640.02	567.98	(72.04)	(11.26)
MFC	МОНОС ХҮНС	7,993,581	716,439,871	106.16	94.56	(11.60)	(10.93)
BOGD	БОГД БАНК	83,213,745	7,023,073,284	91.90	82.66	(9.24)	(10.05)
ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	18,960,124	1,985,958,213	110.81	99.72	(11.09)	(10.01)
KHAN	ХААН БАНК	27,225,176	28,975,867,846	1,107.00	1,010.00	(97.00)	(8.76)
MVO	МОНГОЛ ШЕВРО	163	194,829	1,200.00	1,099.00	(101.00)	(8.42)
UYN	МОНГОЛ САВХИ	4,491	3,530,404	891.42	818.00	(73.42)	(8.24)
DHU	ДАРХАН ХҮНС	750	1,208,823	1,955.00	1,800.00	(155.00)	(7.93)
SBM	ТӨРИЙН БАНК	3,376,345	1,669,650,056	506.51	470.00	(36.51)	(7.21)

Хувьцааны багцын арилжаа

Тайлант хугацаанд 58.13 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 154.93 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 26.70 хувийг эзэлж байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	270,000	810,000,000.00
2	ADB	Ард кредит ББСБ ХК	3,222,566	337,853,819.44
3	APU	АПУ ХК	2,974,820	2,913,261,600.80
4	BNG	Баянгол зочид буудал ХК	23,900	844,300,000.00
5	BOGD	Богд Банк ХК	15,971,720	1,348,277,180.00
6	CUMN	Премигум Нэкеус ХК	27,610,623	4,936,430,616.00
7	GAZR	Газар Шим Үйлдвэр ХК	40,000,000	2,609,600,000.00
8	GLMT	Голомт Банк ХК	3,405,184	4,776,481,607.00
9	INV	Инвекор ББСБ ХК	1,100,661	7,662,560,145.00
10	JGL	Говийн өндөр ХК	62,671	10,277,417.29
11	KHAN	Хаан банк ХК	4,701,110	4,907,570,830.00
12	MGLA	Эм Жи Эл Акуа ХК	2,144,695	386,045,100.00
13	MLG	Монложистикс Холдинг ХК	18,557,241	3,880,867,262.73
14	MNP	Монгол шуудан ХК	629,738	580,631,030.76
15	OLL	Оллоо ХК	1,725,309	29,330,253.00
16	QPAY	Инновэйшн инвестмент ХК	13,420,187	2,789,762,347.50
17	SEND	Сэндли ББСБ ХК	13,928,357	2,557,342,067.07
18	TAS	Эрдэнэт хүнс ХК	368,536	971,829,432.00
19	TDB	Худалдаа Хөгжлийн банк	95,560	3,074,780,000.00
20	UID	Улсын их дэлгүүр ХК	4,722,353	12,703,958,775.00
ДҮН			154,935,231.00	58,131,159,483.59

Хувьцааны тендер саналын арилжаа

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн дагуу биржид бүртгэлтэй үнэт цаасыг худалдан авах санал гаргадаг. Тайлант хугацаанд нийт 4 хувьцаат компанийн 3.51 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 12.62 сая ширхэг хувьцааг тендер саналын арилжаагаар арилжсан байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	GOV	ГОВЬ	12,462,347	3,343,149,206.22
2	HBZ	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	1,200	1,736,448.00
3	UNS	УЛААНСАН	36,684	149,377,248.00
4	JGL	ГОВИЙН ӨНДӨР	119,830	19,650,921.70
		ДҮН	12,620,061.00	3,513,913,823.92

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд 85.00 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 850.00 мянган ширхэг, хоёрдогч зах зээлд 25.38 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 377.25 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас арилжсан байна.

Анхдагч зах зээл

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 777 тоот тогтоол болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/343 тоот тушаалын дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан жилийн 18 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 15 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 150,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 1/29 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр амжилттай эхлүүлсэн.

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 87 тоот тогтоол болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/125 тоот тушаалын дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан жилийн 18.5 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 20 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 200,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1273 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

“Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 384 дугаар тогтоол болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон

гүйцэтгэгчийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/334 тоот тушаалын дагуу “Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан , жилийн 17 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 500,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн амжилттай зохион байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 1/2951 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

3. Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа

Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 4.40 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 7.49 сая ширхэг нэгж эрхийг арилжсан байна. Үүнээс "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн 1.16 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.07 сая ширхэг нэгж эрхийг багцын арилжаагаар арилжсан.

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.09.29	2024.09.30	/төг/	/хувь/
XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,881,483	276,286,316	99.36	88.88	(10.48)	(10.55)
MFG	МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ	4,612,483	4,133,520,936	745.18	812.18	67.00	8.99

4. Өрийн хэрэгслийн арилжаа

Өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 615.60 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 6.17 сая ширхэг өрийн хэрэгсэл арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 63.28 хувийг эзэлж байна.

“Ашид Капитал ББСБ” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 45 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/41 тоот тушаалын дагуу “Ашид Капитал ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгож буй 18 сарын хугацаатай, жилийн 18 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэ бүхий 200,000 ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн захиалгыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрүүдэд хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгуулсан ба санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2208 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд өрийн хэрэгсэл санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 249 дүгээр тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/239 тоот тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, нийт 500,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1/2323 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

“Сэндли ББСБ” ХК нийтэд үнэт цаас санал болгов.


Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 287 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн А/219 тоот тушаал, “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК-ийн 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 24/169 албан тоотыг тус тус үндэслэн “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй 24 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 10,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 100,000 ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 1/2727 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

5. Зах зээлийн үнэлгээ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,795.30 тэрбум төгрөг буюу 17.45 хувиар өсөж, 12 их наяд 084.15 тэрбум төгрөг болсон байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ




ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ


СНМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
		/төгрөг/
KHAN	ХААН БАНК	1,931,319,980,000.0
TTL	ТАВАН ТОЛГОЙ	1,708,459,088,000.0
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	1,241,746,748,580.0
APU	АПУ	1,049,112,742,209.5
GLMT	ГОЛОМТ БАНК	879,010,491,622.0
XAC	ХАС БАНК	801,220,497,000.0
INV	ИНВЕСКОР ББСБ	608,984,019,240.0
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	567,246,491,768.0
SBM	ТӨРИЙН БАНК	354,895,237,500.0
MIK	МИК ХОЛДИНГ	331,349,120,000.0
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС ХК	201,701,903,194.7
GOV	ГОВЬ	198,936,488,625.0
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	163,537,469,550.0
SUU	СҮҮ	136,247,039,145.1
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	129,766,134,585.5
UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	122,936,488,500.0
GTL	ГУТАЛ	113,400,720,000.0
BOGD	БОГД БАНК	103,325,000,000.0
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	102,023,632,254.0
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	76,772,067,629.0
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	71,250,629,371.8
TUM	ТҮМЭН ШУВУУТ	68,186,000,000.0
MGLA	ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК	59,123,788,688.0
MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	58,727,074,124.7
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	58,707,547,143.0
VIK	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	46,000,000,000.0
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	44,150,609,152.0
QPAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК	42,156,577,371.6
BUK	УБ-БУК	39,858,892,500.0
MFC	МОНОС ХҮНС	38,660,896,471.7
ДҮН		11,348,813,374,225.6
Нийтэд эзлэх хувь		93.91

6. ИНДЕКС

Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 50 741.39 нэгж, доод үзүүлэлт 40 704.45 нэгж, дундаж үзүүлэлт 44 742.05 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 427.59 нэгжээр буюу 35.07 хувиар өсөж, 47 864.47 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-A индексийн дээд үзүүлэлт 19 385.82 нэгж, доод үзүүлэлт 16 294.41 нэгж, дундаж үзүүлэлт 17 543.88 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 110.70 нэгжээр буюу 20.40 хувиар өсөж, 18 360.61 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-B индексийн дээд үзүүлэлт 15 444.11 нэгж, доод үзүүлэлт 11 321.67 нэгж, дундаж үзүүлэлт 12 981.61 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 212.71 нэгжээр буюу 26.34 хувиар өсөж, 15 410.49 нэгж болсон байна.

